



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/150

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн
алба ОНӨААТҮГ-ын эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9 502 000 /есөн сая таван зуун хоёр мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ /О.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад дурдсан 2 нэр төрлийн 3 900 000 /гурван сая есөн зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 7 нэр төрлийн 5 602 000 /таван сая зургаан зуун хоёр мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд холбогдо өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ /О.Уранчимэг/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000431

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын
даргын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн
8/150... дугаар тушаалын хавсралт

ДАНСНААС ХАСАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллагын нэр: "Налайх дүүргийн цэцэрлэгжүүлэлтийн алба" ОНӨААТҮГ

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | ЭБХХХ комиссын шийдвэр |
|-----------------------------------|--------------------|---------------|-------------|------------|-------------|---------------------|---------------------|--------------|-------------------|------------------|------------------------|
| Тоног төхөөрөмж | | | | | | | | | | | |
| 1 | Сантехникийн крант | 3 | ш | 50 | 19,000.00 | 950,000.00 | 950,000.00 | - | эвдэрч муудсан | актлах | татах |
| 2 | Сантехникийн муфт | 3 | ш | 100 | 1,000.00 | 100,000.00 | 100,000.00 | - | эвдэрч муудсан | актлах | татах |
| 3 | Төмөр муфт | | ш | 40 | 1,800.00 | 72,000.00 | 72,000.00 | - | эвдэрч муудсан | актлах | татах |
| 4 | Төмөр крант | 3 | ш | 20 | 20,000.00 | 400,000.00 | 400,000.00 | - | эвдэрч муудсан | актлах | татах |
| 5 | Усны шланк | 3 | ш | 100 | 3,800.00 | 380,000.00 | 380,000.00 | - | тасарч цоорсон | актлах | татах |
| 6 | Усны шланк 32 | 3 | ш | 600 | 4,900.00 | 2,940,000.00 | 2,940,000.00 | - | тасарч цоорсон | актлах | устгах |
| 7 | Усны шланк 25 | 3 | ш | 200 | 4,800.00 | 960,000.00 | 960,000.00 | - | тасарч цоорсон | актлах | устгах |
| 8 | Хар тор | 3 | ш | 14 | 150,000.00 | 2,100,000.00 | 2,100,000.00 | - | тасарч цоорсон | актлах | татах |
| 9 | цахилгаан хадуур | 3 | ш | 2 | 800,000.00 | 1,600,000.00 | 1,600,000.00 | - | ашиглах боломжгүй | актлах | татах |
| Тоног төхөөрөмжийн дүн | | | | 1,126 | | 9,502,000.00 | 9,502,000.00 | | | | |
| Нийт данснаас хасах хөрөнгийн дүн | | | | | | 9,502,000.00 | 9,502,000.00 | | | | |
| Үүнээс татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | 5,602,000.00 | | | | | |
| Актлах хөрөнгө | | | | | | 3,900,000.00 | | | | | |